



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.20 № 01/6704
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2-т "Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах" бүрэн эрхийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны баталсан дүрэм, журам, шийдвэрийг хянаж ажилладаг билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор (2 дугаар хавсралт) баталсан "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ыг хянан үзээд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохих өөрчлөлтийг оруулах санал, зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариу мэдэгдэхийг хүсье.

Хувийг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

Авлигатай тэмцэх газрын
2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн
07/... дугаар албан бичгийн хавсралт
6704

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 346 ДУГААР
ТОГТООЛООР БАТАЛСАН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ СУРГАЛТЫН
ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМД ӨГЧ БУЙ ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Журмын 1.1-т “Өмчийн бүх хэлбэрийн дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-д зохих журмын дагуу бакалаврын хөтөлбөрт элсэн суралцаж байгаа шилдэг суралцагч болон гадаадын их, дээд сургуульд магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцах иргэнд Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгохтой холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна” гэж заасан нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3.1.4. **суралцагчийн тэтгэлэг** гэж тодорхой зааж өгсөн байтал тус журамд сургалтын тэтгэлэг гэж хуульд зааснаас өөрөөр томъёолон хэрэгжүүлсэн байгааг нийцүүлэх;

Зөвлөмж 2. Журмын 1.5-т “Тухайн жилд суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ болон хяналтын тоог тэтгэлгийн төрөл тус бүрээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн заалтад тухайн жилд суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ болон санхүүжилтийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон холбогдох байгууллагатай хамтран баталж, хэрэгжүүлэх талаар тодорхой, нарийвчлан тусгах;

Зөвлөмж 3. Журмын 2.3.1-т “Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог “Times Higher Education World University Rankings” болон “Academic Ranking of World Universities” байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 100-д багтсан их, дээд сургуулийн магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцах шаардлагыг хангаж, урилга авсан байх” гэсэн нь гадаадын их, дээд сургуулийн бакалавр, магистр, докторын тэтгэлэгт хөтөлбөрт элсэн суралцагчдын хэлний урилгын нөхцөл, шаардлагыг тодорхой заагаагүй учраас хэлний бэлтгэл хөтөлбөрийн урилгатай иргэнийг элсүүлэх боломж бүрдсэнийг анхаарах;

Зөвлөмж 4. Журмын 2.3.2-т “IELTS-ийн 6, IBT TOEFL-ийн 90 оноо эсхүл бусад гадаад хэлний эдгээртэй дүйцэхүйц олон улсын шалгалтын онооны шаардлага хангасан байх” гэснийг олон улсын шаардлага болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгоход баримталж буй шалгуур, шаардлагатай уялдуулах;

Зөвлөмж 5. Журмын 3.3-т “Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтын зарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зарлана” гэснийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.6-д заасан зохицуулалттай нийцүүлэн сонгон шалгаруулалтыг ямар хугацаанд хэзээ, хэрхэн нь зохион байгуулахыг тодорхой болгох, ил тод байдлыг сайжруулах;

Зөвлөмж 6. Журмын 3.4-т “Тэтгэлэгт хамрагдах иргэн нь журамд заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийг бүрдүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд бүртгүүлнэ” гэсэн нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр,

хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг ил тод байршуулах гэсэн заалтыг үндэслэн иргэн ямар нотлох баримт бичиг бүрдүүлж, хэрхэн бүртгүүлэхийг тодорхой тусгах;

Зөвлөмж 7. Журмын 3.6-д “Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг холбогдох хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, суралцагч бүрд цаг хугацаа, орон зай, байршлаас үл хамаарсан тэгш боломж олгох хэлбэрээр зохион байгуулна” гэснийг тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, суралцагч бүрд цаг хугацаа, орон зай, байршлаас үл хамаарсан тэгш боломж олгох хэлбэрээр зохион байгуулах, **энэ талаар мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх**” гэсэн агуулгыг өөрчлөн тусгах;

Зөвлөмж 8. Журмын 4.1.1-т “Энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг ханган дотоодын сургалтын байгууллагад суралцах 50 хүртэлх суралцагч тус бүрд 10,000,000.0 (арван сая) хүртэл төгрөгийн тэтгэлэг олгоно” гэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дүгээр зүйлд заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Авлигын эсрэг хуулийн 3.1.4 дүгээр зүйлд заасан “давуу байдал олгох” эрсдэлтэй байх тул тухайн шатны сургалтын байгууллагуудын сургалтын төлбөрийн дундажтай уялдуулан тооцоолол хийж, жил бүр шинэчлэн тогтоох аргачлалыг бий болгон, ашиглах талаар өөрчилж тусгах;

Зөвлөмж 9. Журмын 4.1.2-т “Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан дэлхийн шилдэг их, дээд сургуульд магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах 50 хүртэлх суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно” гэж заасныг журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан дэлхийн шилдэг их, дээд сургуульд магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах 50 хүртэлх суралцагчид **үндсэн ангийн хичээлийн багц цагийн** сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох гэсэн агуулгаар зохицуулалтыг тодорхой болгох;

Зөвлөмж 10. Журмын 4.2-т “Суралцагчид тэтгэлгийг сургалтын хөтөлбөрт заасан хугацаанд олгоно” гэсэн нь суралцах дундаж хугацааны хязгаарлалтыг тодорхой тогтоосон хугацаанаас үндэслэлгүй илүү хугацаанд тэтгэлэг авах, сургалтын хөтөлбөрт заасан хугацаандаа суралцахгүй байх, сургуулиа орхих, солих, дахин давтан болон үргэлжлүүлэн суралцах эрсдэлтэй тул суралцагчдын тэтгэлэгт хамрагдах хугацааг тодорхой тусган оруулж, нарийвчлан зохицуулах;

Зөвлөмж 11. Журмын 7.1-т “Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчтай Боловсролын зээлийн сан гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэснийг “Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад **хууль тогтоомж, журмын дагуу шалгуур хангаж, тэнцсэн** суралцагчтай Боловсролын зээлийн сан гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах ажлыг зохион байгуулж ажиллана” гэсэн агуулгыг тусган өөрчлөх;

Зөвлөмж 12. Журмын 7.2-т “Тэтгэлгийн сонгон шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, тэтгэлгийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн, **гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, зохих ёсоор гэрээг дүгнээгүй зэрэг тохиолдолд** буруутай этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх, **төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх** талаар нэмж тусгах;

Зөвлөмж 13. Журмын 7.3-т “Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргааныг энэ журмын 3.2-т заасан Ажлын хэсэг шийдвэрлэнэ” гэсэн нь тухайн Ажлын хэсэг өөрөө шалгаж шийдвэрлэхээр тусгасан нь учир дутагдалтай байх бөгөөд Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 8.3, Авлигын эсрэг хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй, хөндлөнгийн хяналттай байхаар зохицуулалтыг тусгах;

Зөвлөмж 14. Журмын 7.4-т “Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулна” гэсэн нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын нэр заалтыг тодорхой тусгаж өгөөгүй хэт ерөнхий тул Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолын хавсралт Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журамтай нийцүүлэх;

Зөвлөмж 15. Журмын 6.3-т “...гэрээний дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 5-аас доошгүй жил ажиллана” гэсэн нь хэт ерөнхий төрийн болон тухайн ажиллах байгууллага нь тодорхойгүй байх тул заалтыг бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлана гэх зэргээр тодорхой болгон өөрчлөх;

Зөвлөмж 16. Боловсролын зээлийн сангаас гадаадын их, дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан иргэний барьцаа хөрөнгийг баталгаа болгон гаргуулж, улсын бүртгэлд барьцаалсан талаар тэмдэглэгээ хийлгэх, сангаас зээл, тэтгэлэг авсан хүн тус бүрийн талаарх мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэж, эргэн төлөлтөд хяналт тавих асуудлыг тус тус тусган, зохицуулалтыг тодорхой болгон сайжруулж, хийдлийг арилгана уу.

---oOo---